

Н.Золжаргал: Жирийн нөхцөлд ханш уруу орох зохимжгүй

Монголбанкны дэд ерөнхийлөгч Н.Золжаргалаас дараахь асуултад хариулт авлаа..

-Монголбанк валютын ханшийг хөөрөгдөж алдагдлаа нөхсөн гэдэг үндэслэлийг ажлын хэсгээс гаргасан. Үүн дээр ямар байр суурьтай байгаа вэ?

-Монголбанкнаас олон талын судалгааг баггаасан зузаан хавтастай материалыг ажлын хэсэгт өгсөн. Энэ хугацаанд банкуудад ч судалгаа хийсэн. 2010 оноос Монголбанкны балансын алдагдал бүртгэгдээд явдаг болсон. Монголбанк тэнцлийн ашиг, алдагдалд зориулж ханшийн бодлого явуулдаггүй. Энэ хоёр тусдаа зүйл. Ажлын хэсэг хоёр ч удаа хуралдах гээд(ирц нь хүрсэнгүй. Эдийн засгийн байнгын хороон дээр өмнөх долоо хоногт хэлэлцэх үеэр ирц хангалтгүй байсан. Өнөөдөр ажлын хэсгийн нэгтгэсэн дүгнэлт гараагүй гээд хойшлогдлоо. Ажлын хэсгийнхэн үүнийг сайн судалж үзээгүй юм шиг байгаа юм.

-Өнгөрсөн хугацаанд валютын ханшийг тогтворжуулах талаар ямар арга хэмжээ авсан бэ?

- Ханш гэдэг бол эдийн засгийн гол хөшүүргийн нэг. Тоо ярих нь зохимжгүй. Ханшийн хатуу дэглэмтэй улсууд бий. Бид 20-иод жилийн өмнө ч ийм байсан. Тэгэхээр хөвөгч ханшийн одоогийн төвшний талаар Монголбанкны байр суурь хатуу байдаг. Үүнийг УИХ-ын Мөнгөний бодлогын тогтоолд "Монгол ханш чөлөөтэй хөвдөг ханшийн системтэй байна" гэж зааж өгсөн. Сүүлийн үед энэ асуудал их хөндөгдөж байна. Өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтөд шатахууны огцом өсөлт нөлөөлж байгаа. Энэ үед бид ханшаа тогтвортой байлгах үүднээс ханшийн интервенцүүдийг сүүлийн хэдэн долоо хоногийн дотор нэлээд хийсэн. Сүүлийн 10-аад хоногоос ханш тогтвортой болсон. Жирийн нөхцөлд ханш уруу орох зохимжгүй.

-Нефть импортлогчдоос үнэ бууруулахыг үүрэгдэж байгаа ч тэд валютын ханш ярьсаар байгаа. Дахиад доллартай холбоотой асуудал үүсвэл яах вэ?

-Экспорт, импортын нөхцөл байдал, валютын орох, гарах урсгалаас шалтгаалан ханш чөлөөтэй хөвдөг. Үүнтэй хэн ч маргахгүй. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ханш сул эсвэл, ханш байх ёстой төвшингөөс хэтэрхий чанга байх нь хэнд муу нөлөөтэй байх тухай ерөөсөө ярьсангүй. Монгол орны нөхцөлд ханш хэтэрхий чанга байвал ажил олгогчид, бараа үйлдвэрлэдэг үйлдвэрүүдэд сөргөөр нөлөөлнө. Байх ёстой төвшингөөс чанга байгаа ханш Улаанбаатарт байгаа ажлын байруудыг БНХАУ-ын Эрээн хот уруу нүүлгээд байна гэсэн үг. Зөвхөн ханшийн өнцгөөс бүгдийг хараж, зөв бурууг олно гэдэг өрөөсгөл. Зах зээлийн эрэлт нийлүүлэлтээр ханш зохицуулагдаж байгааг харах ёстой.

Ц.ЖАРГАЛЦЭЦЭГ